



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

“ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ”  
ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ч.САЙНБИЛЭГ  
ТАНАА

2015. 04. 02 № 2/44

**Зөрчлийг арилгах тухай**

Үндэсний аудитын газрын Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь заалтыг баримтлан уг хуулийн хэрэгжилтийг хянахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2015 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн А/19 дүгээр тушаалаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хэсгийг Захиргаа, хүний нөөцийн газрын захирлаар ахлуулсан нэр бүхий 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, ажлын хэсгээс хуулийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөө боловсруулсан боловч одоогоор батлуулж албажуулаагүй;
- Компанийн erdenestt.mn цахим хуудсанд Шилэн данс /төсөв, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт, үнэт цаас, байгууллага гэсэн дэд цэсүүдтэй/ цэс нээсэн боловч ямар нэгэн мэдээлэл байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна”, 3.1.1-д “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.1.1-д “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.3-т “тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан”, 6.4.4-т “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 7 дугаар зүйлийн 7.1-д “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ”, 7.1.3-т “тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “... алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн доорх **АЛБАН ШААРДЛАГА** өгч байна. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг цахим хуудаст байршуулж, хуулийн хэрэгжилтийг тогтмол хангаж ажиллах;
2. Албан шаардлагаар өгсөн үүргийн биелэлтийг 2015 оны 4 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Энхбат, Захиргаа, хүний нөөцийн газрын захирал С.Ганболд, Нягтлан бодох бүртгэлийн газрын захирал Д.Чулуунбат, ерөнхий нягтлан бодогч Л.Майцэцэг нарт даалгав.

АХЛАХ АУДИТОР



Г.ЮРА